

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум дахь Хэнтий шинэс сум дундын ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2023/11/НА-СТА-ОНА

Цахим хаяг:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот

2023 он

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: [Khentii@audit.gov.mn](mailto:Khentii@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: [oyuntuyad@audit.gov.mn](mailto:oyuntuyad@audit.gov.mn)

Аудитор: Д.Эрдэнэтуяа  
Утас: 99569599 Цахим хаяг:  
[Erdenetuyade@audit.gov.mn](mailto:Erdenetuyade@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

Анх. 03. 20 № 315  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г \_\_\_\_\_ Г

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМ  
ХЭНТИЙ ШИНЭС СУМ ДУНДЫН ОЙН  
АНГИЙН ДАРГА Г.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий шинэс сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хэнтий шинэс сум дундын ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, ебаримтгүй 20,070.0 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан, 2,019.6 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт, гарын үсэг дутуу баримтаар зарцуулсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн ба зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгө 2,389.3 мянган төгрөг, бараа материал 16,747.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 19,381.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, нийт 38,518.26 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

232330488

Борлуулалтын орлого 38,241.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 44,427.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж үйл ажиллагааны зардалд 121,118.5 мянган төгрөгийг зарцуулж, 38,518.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант хугацаанд 170.5 га талбайд мод бэлтгэх талбай тусгаарлах гэрээ байгуулж 12,787.5 мянган төгрөгийн орлого олсон байна.

#### **Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,439.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 1,350.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,019.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 22,070.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч шийдвэрлэв.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/172, 116 тушаалаар ойжуулалт ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинэчлэн тогтоосныг үндэслэн өөрийн орлогыг бүрэн төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>52,377,372.34</u></b>	<b><u>19,137,169.17</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	32,019,023.17	2,389,274.17
<b>311</b>	Кассанд байгаа бэлэн мөнгө		
<b>312</b>	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,019,023.17	2,389,274.17
<b>3121</b>	Төгрөг	32,019,023.17	2,389,274.17
31213	Арилжааны банк дахь харилцах	32,019,023.17	2,389,274.17
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	595,354.17	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	19,762,995.00	16,747,895.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	258,900.00	258,900.00
35110	Тусгай зориулалттай материал	258,900.00	258,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	19,504,095.00	16,488,995.00
35410	Бичиг хэргийн материал	113,100.00	98,000.00
35420	Аж ахуйн материал	9,185,995.00	9,185,995.00
35470	Бусад хангамжийн материал	10,205,000.00	7,205,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,589,858.70</u></b>	<b><u>19,381,086.94</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	24,589,858.70	19,381,086.94
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	24,589,858.70	19,381,086.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	54,130,132.00	54,130,132.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(43,808,474.90)	(49,994,641.06)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,868,279.00	8,868,279.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,679,904.07)	(6,159,472.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,577,700.00	2,577,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,819,771.50)	(2,095,234.83)
39212	Хуримтлагдсан элэгдэл	(23,504,977.83)	(26,872,551.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,826,876.00	38,926,876.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>76,967,231.04</u></b>	<b><u>38,518,256.11</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>76,967,231.04</u></b>	<b><u>38,518,256.11</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	76,967,231.04	38,518,256.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	66,526,299.00	66,526,299.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	66,526,299.00	66,526,299.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	10,440,932.04	(28,008,042.89)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,975,639.41)	10,440,932.04
51220	Тайлант үеийн үр дүн	13,416,571.45	(38,448,974.93)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>76,967,231.04</u></b>	<b><u>38,518,256.11</u></b>

## 2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>117,014,960.00</b>	<b>82,669,620.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,434,960.00</b>	<b>38,241,720.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	59,434,960.00	38,241,720.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	59,434,960.00	38,241,720.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>57,580,000.00</b>	<b>44,427,900.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	57,580,000.00	44,427,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,580,000.00	44,427,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>103,598,388.55</b>	<b>121,118,594.93</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>103,598,388.55</b>	<b>121,118,594.93</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	100,977,159.16	117,909,326.17
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,724,581.45	51,043,685.87
210101	Үндсэн цалин	44,724,581.45	47,119,535.50
210102	Нэмэгдэл		3,924,150.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,497,912.99	6,352,710.37
210201	Тэтгэврийн даатгал	3,992,755.72	4,387,981.44
210202	Тэтгэмжийн даатгал	420,739.91	510,388.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	336,911.77	408,310.76
210204	Ажилгүйдлийн даатгал	68,567.77	94,583.82
210205	Эрүүл мэндийн даатгал	678,937.82	951,446.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	113,633.00	129,310.00
210301	Гэрэл, цахилгаан	113,633.00	129,310.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,511,812.00	19,373,811.00
210401	Бичиг хэрэг	534,000.00	600,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,411,107.00	18,366,411.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,805.00	257,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,050.00	150,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	924,850.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,703,000.00	5,786,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		320,000.00
210604	Урсгал засвар	8,703,000.00	5,466,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	966,000.00	904,000.00
210702	Дотоод албан томилолт	966,000.00	904,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,913,051.00	20,974,537.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,132,700.00	19,899,944.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	588,000.00	588,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		42,500.00
210807	Газрын төлбөр	66,176.00	319,918.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,547,168.72	13,345,271.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,172,500.00	3,036,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,374,668.72	10,308,771.76
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,621,229.39	3,209,268.76
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	397,600.00	470,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	397,600.00	470,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,223,629.39	2,739,268.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,223,629.39	2,739,268.76
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>13,416,571.45</b>	<b>(38,448,974.93)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>13,416,571.45</b>	<b>(38,448,974.93)</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,526,299.00		(2,975,639.41)	63,550,659.59
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,526,299.00	-	(2,975,639.41)	63,550,659.59
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			13,416,571.45	13,416,571.45
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,526,299.00	-	10,440,932.04	76,967,231.04
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	66,526,299.00	-	10,440,932.04	76,967,231.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,526,299.00	-	10,440,932.04	76,967,231.04
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			(38,448,974.93)	(38,448,974.93)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	66,526,299.00	-	(28,008,042.89)	38,518,256.11

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>117,014,960.00</b>	<b>82,669,620.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,434,960.00</b>	<b>38,241,720.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	59,434,960.00	38,241,720.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	59,434,960.00	38,241,720.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>57,580,000.00</b>	<b>44,427,900.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	57,580,000.00	44,427,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,580,000.00	44,427,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>92,565,962.00</b>	<b>112,299,369.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>92,565,962.00</b>	<b>112,299,369.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>89,842,632.61</b>	<b>109,090,100.24</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	44,724,581.45	51,043,685.87
210101	Үндсэн цалин	44,724,581.45	47,119,535.50
210102	Нэмэгдэл		3,924,150.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,497,912.99	6,352,710.37
210201	Тэтгэврийн даатгал	3,992,755.72	4,387,981.44
210202	Тэтгэмжийн даатгал	420,739.91	510,388.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	336,911.77	408,310.76
210204	Ажилгүйдлийн даатгал	68,567.77	94,583.82
210205	Эрүүл мэндийн даатгал	678,937.82	951,446.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	113,633.00	-
210301	Гэрэл, цахилгаан	113,633.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,511,812.00	19,373,811.00
210401	Бичиг хэрэг	534,000.00	600,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,411,107.00	18,366,411.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	541,805.00	257,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,050.00	150,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	924,850.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,553,000.00	5,786,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	350,000.00	320,000.00
210604	Урсгал засвар	7,203,000.00	5,466,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	966,000.00	904,000.00
210702	Дотоод албан томилолт	966,000.00	904,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,315,693.17	22,593,393.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,535,342.17	21,518,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	588,000.00	588,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	44,500.00	42,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		42,500.00
210807	Газрын төлбөр	66,176.00	319,918.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,160,000.00	3,036,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,160,000.00	3,036,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,723,329.39</b>	<b>3,209,268.76</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	397,600.00	470,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	397,600.00	470,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,325,729.39	2,739,268.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,325,729.39	2,739,268.76
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>24,448,998.00</b>	<b>(29,629,749.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	24,448,998.00	(29,629,749.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	7,570,025.17	32,019,023.17
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	32,019,023.17	2,389,274.17

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 1,350.0 мянган төгрөгийн 1 алдаа <sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1,350.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: Хэнтий шинэс сум дундын ойн анги нь биетээр авсан 1,350.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй зөрчлийг аудитын явцад залруулсан

Аудитаар нийт 24,089.63 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,019.63 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 22,070.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Албан шаардлага

1. Тайлант онд 2,019.6 мянган төгрөгийн шатахууныг анхан шатны баримтын бүрдэлгүй, жолоочийн тооцооны хуудсанд спидометрийн заалт, гарын үсэг дутуу баримтаар зарцуулсан байна.

#### 3.2 Зөвлөмж

##### 1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Мөнгөн зардлын гүйлгээнд түүврийн сорил хэрэгжүүлэхэд анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ебаримтгүй 22,070.0 мянган төгрөгийн мөнгөн зардлын гүйлгээ гаргасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын “Маягт заавар батлах тухай” 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Мөнгөн зарлагын гүйлгээг хийхдээ холбогдох хууль, журмын дагуу анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлж, төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг хийхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

